ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хүүхдийн 4-р цэцэрлэгийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДГА-2023/158/НА-СТА-ТШЗ**

---


Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn

Дорноговь аймаг

Сайншанд сум

2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 261665, 70522734
Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас:70523020
Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа
Утас: 99048991

Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2023.02.24 № 1-6/141

танай ________ -ны № ________ -т

ЗАМЫН-ҮҮД СУМЫН ХҮҮХДИЙН
4-Р ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Н. СҮХТОГОО ТАНАА

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хүүхдийн 4-р цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хүүхдийн 4-р цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагын үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Илрүүлэлтээр Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих нийт 614.4 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 498.0 сая төгрөгийн 26 гүйлгээ, 5.4 сая төгрөгийн 5 шийдвэрийг хугацаа хоцроосон. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 28.9 сая төгрөгийн орлогын 4 гүйлгээ, 42.2 сая төгрөгийн зарлагын 6 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 2.8 сая төгрөгийн 2 шийдвэрийн мэдээллийг огт мэдээлээгүй байна. Мөн Шилэн дансны

0100[illegible]94[illegible]5

тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"; заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайлангаарх Засгийн газрын өмчийн дүн улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх өмчийн дүнгээс 33.7 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Мөн Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7 дугаар зүйл "Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн төрөл"-ийн "7.1.3.хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлтийн" болон 14 дүгээр зүйлийн "14.2.Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд энэ хуулийн 6, 7, 8 дугаар зүйлд заасан улсын бүртгэлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй" заалтуудтай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Анхан шатны баримтын тулгалтаар 19 харилцагчдаас 22.4 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Энэ нь үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтууд, НӨАТ-ын тухай хуулийн 17.3.2-т "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Эд хөрөнгийн тооллого чанартай хийгдээгүй, тооллого дууссаны дараах хурлын тэмдэглэл хөтлөөгүй, тооцоо бодсон актад хэзээ тоолсон нь тодорхойгүй байна. Мөн УСНББОУС-1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын.....ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 20-р зүйлийн 20.2.6-д заасан "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн хуулийн заалтуудыг хангаж ажиллаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эд хариуцагчийн гаргасан тайланг нягтлан бодогч сар бүр хянаж гарын үсгээр баталгаажуулсан ч тайланг Сангийн Сайдын баталсан маягтын дагуу бараа материалын орлого, зарлага, эхний болон эцсийн үлдэгдлийн тоо ширхэг, хэмжээг тодорхой гаргаагүй байна. Энэ нь УСНББОУС-1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.3, 20.2.6-д заасан "аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын үсэг зурах", "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 9 зорилт, 22 арга хэмжээний хэрэгжилт 93 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 98.5 хувийн биелэлттэй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т. ГАН-ӨЛЗИЙ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **103,431,842.93** | **115,720,415.82** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 8,920,054.40 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 8,920,054.40 |
| **3121** | **Төгрөг** | - | 8,920,054.40 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 8,920,054.40 |
| **33** | **АВЛАГА** | 523,490.00 | 879,145.39 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 25,200.00 | 879,145.39 |
| **335** | **Бусад авлага** | 498,290.00 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 498,290.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 102,908,352.93 | 105,921,216.03 |
| **351** | **Түүхий эд материал** | 30,210,815.03 | 30,697,865.03 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 27,132,315.03 | 27,735,415.03 |
| 35130 | Эм боох материал | 3,078,500.00 | 2,962,450.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 601,000.00 | 334,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 72,096,537.90 | 74,889,351.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 826,830.00 | 1,142,220.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 61,629,125.00 | 61,150,558.00 |
| 35460 | Хүнсний материал | 8,772,332.90 | 12,558,973.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 868,250.00 | 37,600.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,047,273,144.32** | **1,122,295,660.35** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,047,273,144.32 | 1,122,295,660.35 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,011,919,327.54 | 1,087,430,243.57 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,052,227,970.00 | 1,146,712,835.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (66,722,171.76) | (89,750,269.53) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 63,762,200.00 | 43,811,840.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (43,360,828.18) | (19,312,388.42) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 38,195,343.00 | 14,348,854.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (32,292,885.52) | (8,490,327.48) |
| 39217 | Ном | 109,700.00 | 109,700.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 35,353,816.78 | 34,865,416.78 |
| 39301 | Програм хангамж | 2,442,000.00 | 2,442,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (748,183.22) | (1,236,583.22) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 33,660,000.00 | 33,660,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,150,704,987.25** | **1,238,016,076.17** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **3,768,472.95** | **894,388.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 3,768,472.95 | 894,388.00 |
| **413** | **Өглөг** | 3,768,472.95 | 894,388.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 2,874,084.95 | - |
| **4136** | **Бусад өглөг** | 894,388.00 | 894,388.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 894,388.00 | 894,388.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,146,936,514.30** | **1,237,121,688.17** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,146,936,514.30 | 1,237,121,688.17 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 33,660,000.00 | 33,660,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 33,660,000.00 | 33,660,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,051,401,824.30 | 1,141,586,998.17 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,051,401,824.30 | 1,051,401,824.30 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 90,185,173.87 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 61,874,690.00 | 61,874,690.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,150,704,987.25** | **1,238,016,076.17** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **476,117,753.95** | **703,010,597.18** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **105,096,761.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 105,096,761.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 10,392,446.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | 10,392,446.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 94,484,865.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | | 219,450.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **476,117,753.95** | **597,913,836.18** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 414,471,800.00 | 504,010,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 504,010,100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 414,471,800.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 194,000.00 | 6,501,790.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 5,900,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 194,000.00 | 103,500.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 498,290.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 61,451,953.95 | 87,401,946.18 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 61,451,953.95 | 87,401,946.18 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **517,299,563.75** | **612,804,089.98** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **517,299,563.75** | **612,804,089.98** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 509,058,458.56 | 612,804,089.98 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 332,372,540.13 | 387,413,945.32 |
| 210101 | Үндсэн цалин | 244,805,250.05 | 294,419,787.59 |
| 210102 | Нэмэгдэл | 74,099,318.13 | 75,607,709.00 |
| 210104 | Урамшуулал | 13,467,971.95 | 17,386,448.73 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 42,735,700.00 | 48,612,499.94 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,943,700.00 | 33,175,382.69 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,198,000.00 | 3,915,527.48 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,650,666.74 | 3,112,261.94 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 639,600.00 | 764,489.47 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,303,733.26 | 7,644,838.36 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 55,051,953.95 | 63,318,746.18 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,945,733.95 | 5,886,294.18 |
| 210302 | Түлш, халаалт | 45,867,380.00 | 39,330,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,238,840.00 | 18,102,452.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 20,948,655.50 | 9,197,907.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 819,500.00 | 1,838,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 350,000.00 | 215,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 539,506.00 | 839,190.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 240,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 925,600.00 | 95,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 18,074,049.50 | 6,210,717.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 19,032,574.90 | 52,322,849.90 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 71,100.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 18,005,474.90 | 52,322,849.90 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 956,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,387,500.00 | 6,300,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,387,500.00 | 6,300,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 372,000.00 | 448,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 372,000.00 | 448,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,329,000.00 | 912,170.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 937,000.00 | 467,170.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 392,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 445,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 31,828,534.08 | 44,277,971.64 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 8,320,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 510,000.00 | 1,223,810.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 31,318,534.08 | 34,733,461.64 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 8,241,105.19 | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 200,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 | - |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 8,041,105.19 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,041,105.19 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(41,181,809.80)** | **90,206,507.20** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 21,333.33 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 21,333.33 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (21,333.33) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(41,181,809.80)** | **90,185,173.87** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **476,616,043.95** | **597,913,836.18** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **6,003,500.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 6,003,500.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | - | 6,003,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 6,003,500.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **476,616,043.95** | **591,910,336.18** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 414,471,800.00 | 504,010,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 504,010,100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 414,471,800.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 692,290.00 | 498,290.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 194,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 498,290.00 | 498,290.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 61,451,953.95 | 87,401,946.18 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 61,451,953.95 | 87,401,946.18 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **462,728,763.95** | **584,093,781.78** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **462,728,763.95** | **584,093,781.78** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **454,487,658.76** | **584,093,781.78** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 307,139,898.81 | 390,056,275.60 |
| 210101 | Үндсэн цалин | 219,597,808.73 | 289,737,775.78 |
| 210102 | Нэмэгдэл | 74,074,118.13 | 83,213,399.21 |
| 210104 | Урамшуулал | 13,467,971.95 | 17,105,100.61 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 42,760,900.00 | 49,130,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,968,900.00 | 33,511,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,198,000.00 | 3,904,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,650,666.74 | 3,123,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 639,600.00 | 781,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,303,733.26 | 7,809,500.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 55,051,953.95 | 63,318,746.18 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,945,733.95 | 5,886,294.18 |
| 210302 | Түлш, халаалт | 45,867,380.00 | 49,744,318.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,238,840.00 | 7,688,134.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,499,506.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 300,000.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 350,000.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 365,506.00 | - |
| 210404 | Ном, хэвлэл | 240,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,250,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,994,000.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 27,592,400.00 | 56,098,500.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 53,700.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 17,346,200.00 | 56,098,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10,192,500.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,400,000.00 | 6,600,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,400,000.00 | 6,600,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 372,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 372,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,329,000.00 | 1,110,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 937,000.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 392,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 1,110,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,342,000.00 | 17,779,360.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 10,429,360.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,342,000.00 | 7,350,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **8,241,105.19** | **-** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 200,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 | - |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 8,041,105.19 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,041,105.19 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **13,887,280.00** | **13,820,054.40** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **13,388,990.00** | **4,900,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **13,388,990.00** | **4,900,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 13,388,990.00 | 4,900,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 10,194,300.00 | 4,900,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 3,194,690.00 | - |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(13,388,990.00)** | **(4,900,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 498,290.00 | 8,920,054.40 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 8,920,054.40 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 33,660,000.00 | - | 1,113,276,514.30 | 1,146,936,514.30 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **33,660,000.00** | **-** | **1,113,276,514.30** | 1,146,936,514.30 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | (61,874,690.00) | (61,874,690.00) |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **33,660,000.00** | **-** | **1,051,401,824.30** | 1,085,061,824.30 |
| D01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **33,660,000.00** | **-** | **1,051,401,824.30** | 1,085,061,824.30 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | 61,874,690.00 | - | 61,874,690.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **33,660,000.00** | **61,874,690.00** | **1,051,401,824.30** | 1,146,936,514.30 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 90,185,173.87 | 90,185,173.87 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **33,660,000.00** | **61,874,690.00** | **1,141,586,998.17** | 1,237,121,688.17 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | |
|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 597,314,500.00 | 588,993,781.78 | 8,320,718.22 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 597,314,500.00 | 588,993,781.78 | 8,320,718.22 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 597,314,500.00 | 588,993,781.78 | 8,320,718.22 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 397,310,800.00 | 390,056,275.60 | 7,254,524.40 |
| 210101 | Үндсэн цалин | 333,198,200.00 | 289,737,775.78 | 43,460,424.22 |
| 210102 | Нэмэгдэл | 59,896,400.00 | 83,213,399.21 | (23,316,999.21) |
| 210104 | Урамшуулал | 4,216,200.00 | 17,105,100.61 | (12,888,900.61) |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 49,984,900.00 | 49,130,900.00 | 854,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,092,500.00 | 33,511,600.00 | 580,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,973,100.00 | 3,904,800.00 | 68,300.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,178,500.00 | 3,123,900.00 | 54,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 794,700.00 | 781,100.00 | 13,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,946,100.00 | 7,809,500.00 | 136,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 63,321,100.00 | 63,318,746.18 | 2,353.82 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,753,700.00 | 5,886,294.18 | 2,867,405.82 |
| 210302 | Түлш, халаалт | 47,067,400.00 | 49,744,318.00 | (2,676,918.00) |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,500,000.00 | 7,688,134.00 | (188,134.00) |
| **2105** | **Нормативт зардал** | 56,199,600.00 | 56,098,500.00 | 101,100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 56,199,600.00 | 56,098,500.00 | 101,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,600,000.00 | 6,600,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 6,600,000.00 | 6,600,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,110,000.00 | 1,110,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,110,000.00 | 1,110,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 22,788,100.00 | 22,679,360.00 | 108,740.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,438,100.00 | 15,329,360.00 | 108,740.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,350,000.00 | 7,350,000.00 | - |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 597,314,500.00 | 597,913,836.18 | (599,336.18) |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 504,010,100.00 | 504,010,100.00 | - |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 504,010,100.00 | 504,010,100.00 | - |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 87,404,400.00 | 87,401,946.18 | 2,453.82 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 87,404,400.00 | 87,401,946.18 | 2,453.82 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 5,900,000.00 | 6,501,790.00 | (601,790.00) |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,900,000.00 | 6,501,790.00 | (601,790.00) |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **8,920,054.40** | (8,920,054.40) |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 28.00 | 28.00 | - |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 17.00 | 17.00 | - |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 10.00 | 10.00 | - |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 194.00 | 194.00 | - |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | 194.00 | 194.00 | - |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 194.00 | 194.00 | - |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **28.00** | **26.00** | 2.00 |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 17.00 | 17.00 | - |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 1.00 | - | 1.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 10.00 | 9.00 | 1.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **498,290.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **498,290.00** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 498,290.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 498,290.00 |
| 213209 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | | 498,290.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **498,290.00** |
| 213305 | Нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл төвлөрүүлэлт | - | 498,290.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 498,290.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 498,290.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 498,290.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 69.9 сая төгрөгийн 4 алдаа[1] илэрснээс аудитын явцад 69.9 сая төгрөгийн 4 алдааг залрууллаа.Үүнд:

**Залруулсан алдаа:**

1. Дахин үнэлгээний нэмэгдлийн 61.9 сая төгрөгийг бүртгээгүй байсныг залруулсан.
2. Эрх бүхий этгээдийн шийдвэрээр хасагдсан хөрөнгөөс 7.5 сая төгрөгийн хөрөнгө илүү хассан, буцааж орлогоор бүртгээгүй байсныг залруулсан.
3. Төсвийн гүйцэтгэлийн тайлан зөрүүтэй ирснийг залруулсан.
4. Цалингийн зардалд бараа материалын 0.6 сая бүртгэснийг залруулсан.

Аудитаар нийт 6 зөрчил[2] илэрснээс, 0.8 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 4 зөвлөмж өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

Тайлант хугацаанд 2022 оны ажлын үр дүнг үнэлж, сумын Засаг даргын захирамжийг үндэслэн байгууллагын удирдах албан тушаалтанд 12 дугаар сард 70 хувиар буюу 0.8 сая төгрөгийг тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн энэ хуулийн 14.1.18, 14.1.19-д зааснаас бусад төсвийн”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

### 3.2 Албан шаардлага

1. **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих нийт 614.4 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 498.0 сая төгрөгийн 26 гүйлгээ, 5.4 сая төгрөгийн 5 шийдвэрийг хугацаа хоцроосон. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 28.9 сая төгрөгийн орлогын 4 гүйлгээ, 42.2 сая төгрөгийн зарлагын 6 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 2.8 сая төгрөгийн 2 шийдвэрийн мэдээллийг огт мэдээлээгүй байна. Энэ нь төсөв, өмч, хөрөнгө, мөнгө шамшигдуулах, орлого нуун дарагдуулах, зориулалтын бус, үр ашиггүй зарцуулалт хийгдэх үр дагавартай.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:” 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”; заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 3.3 Зөвлөмж

### 1. Засгийн газрын оруулсан капиталтай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Санхүүгийн тайлангаарх Засгийн газрын өмчийн дүн УБГэрчилгээ дээрх өмчийн дүнгээс 33.7 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь үнэн, бодит мэдээллээр хангагдахгүй байх, хууль хэрэгжихгүй байх үр дагавартай.

Мөн Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7 дугаар зүйл "Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн төрөл"-ийн "7.1.3.хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлтийн" болон 14 дүгээр зүйлийн "14.2.Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд энэ хуулийн 6, 7, 8 дугаар зүйлд заасан улсын бүртгэлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй" заалтуудтай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Засгийн газрын оруулсан капиталд өөрчлөлт оруулсан тохиолдолд өөрчлөлтийн талаарх бичиг баримтыг бүрдүүлэн хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлж мэдээллээ шинэчлэх.

### 2. Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Анхан шатны баримтын тулгалтаар 19 харилцагчдаас 22.5 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Энэ нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах үр дагавартай.

Мөн үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 3.1.3-д "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтууд, НӨАТ-ын тухай хуулийн 4.1.14-т "төлбөрийн баримт" гэж тухайн төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийг таних тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг", 17.3.2-т "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" заалттай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Худалдан авалтыг тооцоо хийгдсэн тухай бүрд нь цаасан болон цахим ибаримтыг үндэслэн санхүүгийн тайланд тусгаж ажиллах

### 3. Дотоод хяналттай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Эд хөрөнгийн тооллого чанартай хийгдээгүй, тооллого дууссаны дараах үр дүнг хэлэлцсэн хурлын тэмдэглэл хөтлөөгүй, тооцоо бодсон актад хэзээ тоолсон нь тодорхойгүй байна. Энэ нь өмч, хөрөнгө дутагдах, үр ашиггүй зарцуулагдах үр дагавартай.

Мөн УСНББОУС-1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын.....ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 20-р зүйлийн 20.2.6-д заасан "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн хуулийн заалтуудыг хангаж ажиллаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Нягтлан бодогч жилийн тайланг гаргахын өмнө тооллогыг чанартай зохион байгуулж, тооллогын үр дүнг тооцон, хянан, баталгаажуулалтыг хангаж хариуцлагатай ажиллах.

4. **Дотоод хяналттай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Эд хариуцагчийн гаргасан тайланг нягтлан бодогч сар бүр хянаж гарын үсгээр баталгаажуулаагүй. Энэ нь өмч, хөрөнгө дутагдах, ашиггүй зарцуулагдах, бодитой мэдээллээр хангагдаж чадахгүй байх үр дагавартай.

Мөн УСНББОУС-1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.3, 20.2.6-д заасан "аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын үсэг зурах", "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:Нягтлан бодогч сар бүр эд хариуцагчийн тайланг хянан, тоо ширхэгийг тодорхой гаргаж, гарын үсэг болон бусад баталгаажуулалтыг хангаж хариуцлагатай ажиллах.

Дээрх зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн 61.9 сая төгрөгийг бүртгээгүй байсныг залруулсан. | 1 | 61,874.7 | 0 | - | 1 | 61,874.7 | 1 | 61,874.7 | | | | |
| Эрх бүхий этгээдийн шийдвэрээр хасагдсан хөрөнгөнөөс 7.5 сая төгрөгийн хөрөнгө илүү хассан, буцааж орлого аваагүй байсныг залруулсан. | 1 | 7,452.0 | 0 | - | 1 | 7,452.0 | 1 | 7,452.0 | | | | |
| Төсвийн гүйцэтгэлийн тайлан зөрүүтэй ирсэнийг залруулсан. | 1 | - | 0 | - | 1 | - | 1 | - | | | | |
| Цалингийн зардалд бараа материалын 0.6 сая бүртгэснийг залруулсан. | 1 | 567.3 | 0 | - | 1 | 567.3 | 1 | 567.3 | | | | |
| **Дүн** | **4** | **69,894.0** | **-** | **-** | **4** | **69,894.0** | **4** | **69,894.0** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төг/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангаарх Засгийн газрын өмчийн дүн 33.7 сая төгрөг УБГэрчилгээ дээрх өмчийн дүн “0” байна. | 1 | | | | | | 1 | | | | | |
| Анхан шатны баримтын тулгалтаар 19 харилцагчдаас 22.5 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. | 1 | | | | | | 1 | | | | | |
| Эд хөрөнгийн тооллого чанартай хийгдээгүй, тооллого дууссаны дараах хурлын тэмдэглэл хөтлөөгүй, тооцоо бодсон актад хэзээ тоолсон нь тодорхойгүй байна. | 1 | - | | | | | 1 | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Эд хариуцагчийн гаргасан тайланг нягтлан бодогч сар бүр хянаж гарын үсгээр баталгаажуулаагүй. | 1 | | | | | | 1 | | | | | |
| Тайлант хугацаанд 2022 оны ажлын үр дүнг үнэлж, сумын Засаг даргын захирамжийг үндэслэн байгууллагын удирдах албан тушаалтанд 12 дугаар сард 70 хувиар буюу 0.8 сая төгрөгийг тооцож олгосон байна. | 1 | 827.8 | 1 | 827.8 | | | | | | | | |
| Дүн | 5 | 827.8 | 1 | 827.8 | | | 4 | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Хариуцлага тооцох албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих нийт 614.4 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 498.0 сая төгрөгийн 26 гүйлгээ, 5.4 сая төгрөгийн 5 шийдвэрийг хугацаа хоцроосон. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 28.9 сая төгрөгийн орлогын 4 гүйлгээ, 42.2 сая төгрөгийн зарлагын 6 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 2.8 сая төгрөгийн 2 шийдвэрийн мэдээллийг огт мэдээлээгүй байна. | 1 | - | - | - | 1 | - | | |
| **Дүн** | **1** | **-** | **-** | **-** | **1** | **-** | | |